Үндэсний аудитын газраас 2025 оны Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын зөрчлийн мэдээ FAS системд оруулсан байдлаар

№	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /төг/	Аудитын шийдлийн утга	Биелэлт ирүүлэх огноо	Хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Албан шаардлага	Тайлант онд 3,482.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, чанарын баталгааны барьцаа 1,224.4 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулаагүй байна.	3,482,010,755.00	Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулдаггүй, барьцаа хөрөнгийг үндсэн үйл ажиллагааны харилцах данснаас тусад нь байршуулдаггүй зөрчлийг таслан зогсоох.	10/30/2026	Хугацаа болоогүй
2	Албан шаардлага	Гурвааас дээш жилийн насжилттай 1,795.5 сая төгрөгийн авлагыг шийдвэрлээгүй, 1,363.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны авлагын дансанд хоорондын тооцоогоор баталгаажуулаагүй Зам, тээврийн яамны 38.9 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна.	3,197,896,995.00	Удаан жилийн насжилттай авлагыг барагдуулдаггүй, авлагыг тооцоо нийлж, баталгаажуулдаггүй зөрчлийг арилгах	10/30/2026	Хугацаа болоогүй
3	Зөвлөмж	ТУЗ-ийн үйл ажиллагааны зардал, гишүүдийн цалинг батлуулаагүйгээр цалингийн зардалд 119.3 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 2.0 сая төгрөгийг тус тус зарцуулж, зарцуулалтыг нарийн бичгийн дарга тайлагнаагүй байна.	121,341,727.00	ТУЗ-ийн үйл ажиллагаа, цалингийн зардлыг холбогдох эрх бүхий албан тушаалтнаар батлуулах	10/30/2026	Хугацаа болоогүй
4	Албан шаардлага	Тайлант онд гадаад томилолтод 435.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 арга хэмжээ төлөвлөснөөс 1 арга хэмжээ цуцлагдаж, торгуульд 5.3 сая төгрөгийг төлсөн, яам болон агентлагийн зарим албан хаагчдын 87.2 сая төгрөгийн томилолтын зардлыг санхүүжүүлсэн байна.	92,484,498.00	Бусад байгууллагын албан хаагчдын гадаад томилолтын зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоох.	10/30/2026	Хугацаа болоогүй
5	Албан шаардлага	Гүйцэтгэх захирлын 2025 оны А/233, А/415 дугаар тушаалаар салбар, нэгжийн мөнгөн хөрөнгийн үйл ажиллагааны журмыг батлахдаа зохион байгуулалтын бүтэц, ажлын байрны жагсаалт, орон тоонд батлагдаагүй кассын няравын орон тоог бий болгон 12 ажилтанд ажил хавсран гүйцэтгэх тушаал гаргаж, 30 хувийн цалингийн нэмэгдэл нийт 29.2 сая төгрөгийг олгосон байна.	29,228,112.00	Ажлын байрны жагсаалт, орон тоонд батлаагүй, албан тушаалыг бий болгож, цалингийн нэмэгдэл олгодог зөрчлийг таслан зогсоох	10/30/2026	Хугацаа болоогүй
6	Зөвлөмж	Санхүүгийн тайланд бүртгэлтэй 26 газар бусад байгууллагын нэр дээр гэрчилгээтэй бөгөөд 71.6 сая төгрөгийн 3 газар эзэмших эрхийн гэрчилгээгүй, кадастрын зурагтай 1,228.1 сая төгрөгийн 8 газар, гэрчилгээ, кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй 3,412.1 сая төгрөгийн 2 газар, газрын эзэмших эрхийн хугацаа дууссан 41.0 сая төгрөгийн 3 газар тус тус байна.	3,524,694,000.00	Газар эзэмших эрхийг шилжүүлэн авах, баримт бичгийн зөрчлийг арилгах.	10/30/2026	Хугацаа болоогүй
7	Зөвлөмж	Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал түрээслэгчдийн түрээсийн барьцааг барьцаа хөрөнгийн дансанд тусад нь байршуулаагүй, нийт 16 түрээслэгчдээс 11.1 сая төгрөгийн барьцааг авч холбогдох дансанд шилжүүлээгүй байна.	11,142,840.00	Түрээслэгчдийн гэрээний үүргийг хангуулж, барьцааг холбогдох дансанд байршуулах.	10/30/2026	Хугацаа болоогүй
8	Зөвлөмж	Тайлант онд гүйцэтгэх захирлын 2025 оны А/50 дугаар "Цалин хөлсний сүлжээ, хэмжээг тогтоох тухай", мөн оны А/234 дүгээр "Цалин хөлсний сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай", А/411 дүгээр "Албан тушаалын жагсаалт, цалин хөлсний сүлжээ, хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаалаар ажилтнуудын цалин хөлсийг нэмсэн байна. Үндсэн цалинг нэмэхдээ холбогдох журмуудад заасны дагуу үйл ажиллагааны үр дүнд компанийн орлого өсөж, зардал хэмнэгдсэн, ажлын бүтээмж тасралтгүй өссөн болон хөдөлмөрийн нөхцөл, зах зээл дэх цалингийн түвшин, инфляцтай уялдуулан хийсэн тооцоо судалгаа хангалтгүй, өмнөх онд сар бүр олгодог үр дүнгийн урамшууллын 40 хувийн нэмэгдлийг үндсэн цалин дээр нэмж тогтоосон, гэрээт орон тоонд ажиллуулах ажил үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлаагүй байна.	0	Цалин хөлсний сүлжээ, хэмжээг батлахдаа холбогдох хууль, тогтоомжийг мөрдөх, гэрээт орон тоонд ажиллуулж байгаа үйлчилгээний ажилтны жагсаалтыг шинэчлэн батлах.	10/30/2026	Хугацаа болоогүй
9	Зөвлөмж	ИНЕГ-ын даргын 2024 оны А/486, ИНҮТ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/196 дугаар тушаалаар "Мэргэшсэн зэргийн нэмэгдэл олгох албан тушаалын жагсаалт"-ыг баталсан бөгөөд тайлант онд мэргэжлийн зэргийн нэмэгдэлд нийт 1,409.4 сая төгрөгийг олгосон. Судалгаагаар мэргэжлийн зэргийн нэмэгдлийг 109 ажилтанд олгодог бөгөөд үүнээс 23 ажилтныг түүвэрлэн шалгахад мэргэшсэн няглан бодогчоос бусад мэргэжлийнхэнд салбарын хуулиар зохицуулагдаагүй, тушаал, шийдвэрийг баримтлан олгож байна. Тухайлбал, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын зөвлөх инженерийн эрхтэй нэр бүхий менежерт эрх зүйн чадамжгүй болсон Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/148 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Мэдээлэл, холбооны технологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журам"-ыг баримтлан	0	Мэргэжлийн зэргийн нэмэгдлийг баталж, олгоходоо холбогдох хууль, тогтоомжийг баримтлах .	10/30/2026	Хугацаа болоогүй

10	Албан шаардлага	Тус компанийн орон тооны дээд хязгаарыг ЗТС-ын 2024 оны А/290 дүгээр тушаалаар 2078, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 08/25 дугаар тогтоолоор 1898, мөн оны 12/25 дугаар тогтоолоор 1998 болгож тус тус өөрчлөн батлсан байна. Гүйцэтгэх удирдлага Төлөөлөн удирдах зөвлөлийн 08/25 дугаар тогтоолоор батлсан орон тооны дээд хязгаарыг мөрдөөгүй, ажлын байрны жагсаалт, орон тоог шинэчлэзгүйгээр 162-оор, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12/25 дугаар тогтоолоор шинэчлэн батлсан орон тоог 6-аар тус тус хэтрүүлсэн байна.	0	Эрх бүхий байгууллагаас батлсан орон тооны дээд хязгаарыг мөрдөж ажилладаггүй зөрчлийг таслан зогсоох	10/30/2026	Хугацаа болоогүй
11	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал компанийн бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлсантай холбогдуулан ажил олгогчийн санаачилгаар нийт 21 ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгож, нийт 500.1 сая төгрөгийн тэтгэмж олгосон байна. Тэтгэмж олгохдоо иргэний нисэхийн салбарт ажилласан жилээс хамааруулан олгохоор заасан тэтгэмжийг 7-8 сар ажилласан нийт 5 ажилтанд хөдөлмөрийн дотоод журамд заасан холбогдох заалтуудыг зөрчиж 210.0 сая төгрөгөөр илүү олгосон байна.	210,000,000.00	Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон ажилтанд хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээнд заасан холбогдох заалтуудыг зөрчиж, илүү олгодог зөрчлийг таслан зогсоох	10/30/2026	Хугацаа болоогүй
12	Албан шаардлага	Тус компани нь Эко интернэйшнл тауэр барилгын 23 давхарт 49.63 мкв үйлчилгээний талбайг түрээслэхдээ: - Эрх бүхий байгууллагаас холбогдох зөвшөөрлийг аваагүй, түрээслүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулаагүй; - ТӨБЗГ-аас тогтоосон 1 м.кв талбайн түрээсийн төлбөрийн дээд хязгаар 50,000.00 төгрөгөөс хэтрүүлэн эхний жилд 113,000.00 төгрөгөөр, 2 дахь жилээс 124,000.00 төгрөгөөр тооцож, 2 жилийн хугацаатай гэрээ байгуулж, барьцаа болон түрээсийн төлбөрт 56.1 сая төгрөгийг олгосон байна.	56,081,900.00	Бусдаас байр түрээслэхдээ эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авдаггүй, түрээслүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулдаггүй, 1 м.кв талбайн дээд хязгаарыг баримталдаггүй зөрчлийг таслан зогсоох.	10/30/2026	Хугацаа болоогүй
13	Зөвлөмж	ЗТС-ын 2025 оны А/227 дугаар тушаалаар ИНҮТ ТӨХХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан байна. Гүйцэтгэх удирдлага 2025 оны бизнес төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй, эдийн засгийн үндсэн үзүүлэлтээр баталсан нийт цалингийн сан, нийт авлага, өр төлбөрийн үлдэгдлийн зорилтыг хангаж ажиллаагүй, удирдлагын зардлаар батлуулсан 26,063.3 сая төгрөгийн гүйцэтгэлийг тайлагнаагүй байна.	0	Компанийн бизнес төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, эдийн засгийн зорилтот түвшинг ханган ажиллаж, үр дүнг тайлагнах .	10/30/2026	Хугацаа болоогүй
14	Зөвлөмж	ТУЗ-ийн 2025 оны 12/25 дугаар тогтоолоор 2025 оны орлого, зарлагын шинэчилсэн төлөвлөгөө 29 салбар, нэгжийн зарлагыг 219,546.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд 182,962.5 сая төгрөг буюу 83.3 хувийн гүйцэтгэлтэй байна. ИНҮТ ТӨХХК-ийн 2025 оны зарлагын гүйцэтгэлийн тайланг салбар, нэгжүүдийн тайлан руу хөвөн шалгахад зарлагын гүйцэтгэлийг 565.4 сая төгрөгөөр илүү тайлагнасан, хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг хүрэх үр дүн, зарцуулсан төсөвтэй нь уялдуулан тооцоогүй байна.	565,357,900.00	Салбар нэгжийн тайланг үнэн зөв бэлтгэж, хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээтэй уялдуулан тайлагнах.	10/30/2026	Хугацаа болоогүй
15	Зөвлөмж	Тайлант онд 163,872.9 сая төгрөгийг борлуулалтын өртөөр бүртгэсэн бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өртөг тооцох аргыг тодорхой тусгаагүй, салбар, нэгжүүдийн зардлыг хуримтлуулан болон тооцож, бүртгэхээр заасан боловч тухайн нэгжүүдийг тодорхой болгоогүйгээс өртөгт хуваарилах зардал болон борлуулалт маркетингийн зардал, ерөнхий удирдлагын зардал, бусад зардлуудыг үнэн зөв хуваарилан бүртгэснийг хянах боломжгүй байна.	0	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт борлуулалтын өртөг тооцох, бүртгэх аргачлалыг тодорхой тусгаж, хэрэгжүүлэх, өртгийг үнэн зөв тооцох.	10/30/2026	Хугацаа болоогүй
16	Зөвлөмж	ЗТС, ВХС-ын хамтарсан 2025 оны А/607-А/607 дугаар тушаалаар Монгол улсад нисэх хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэхээр батлсан байна. ТУЗ-ийн 2025 оны 12/25 дугаар тогтоолоор салбарын ой тэмдэглэхэд 1,420.8 сая төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 1,410.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Тухайлбал, Иргэний нисэхийн салбарын ажилтнууд, зочид төлөөлөгчдэд зориулсан гарын бэлэг, 100 жилийн ойн медаль хийлгэхэд 569.5 сая төгрөг, орон нутгийн нисэх буудлуудын ойн арга хэмжээ зохион байгуулахад 110.0 сая төгрөг, Оросын Холбооны Улсын уран нислэгийн багийн агаарын үзүүлбэрт 99.3 сая төгрөгийг зарцуулсан байна.	1,410,149,900.00	Салбарын ой, тэмдэглэлт үйл явдал болон Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх.	10/30/2026	Хугацаа болоогүй
17	Зөвлөмж	ЗТС-ын 2025 оны А/227 дугаар "ИНҮТ ТӨХХК-ийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах тухай" тушаалаар төрийн өмчийн ногдол ашиг 2,446.5 сая төгрөгийг баталсан байна. Тайлант онд орлогын дэлгэрэнгүй тайлангаар 24,911.3 сая төгрөгийн цэвэр ашигтай гарсан бөгөөд ногдол ашгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, ногдол ашгийн хэмжээ, болон төлөх журам, хугацаа тодорхойлоогүй байна.	2,446,525,100.00	Төрийн өмчийн ногдол ашгийг төлөх журам хугацааг тодорхой болгох.	10/30/2026	Хугацаа болоогүй

18	Төлбөрийн акт	Тайлант оны 1-8 дугаар саруудад дотоод томилолтоор ажилласан 375 ажилтны (давхардсан тоогоор) цалин хөлсийг тооцохдоо томилолтоор ажилласан хугацаанд нийт 62.4 сая төгрөгийн хоолны мөнгө давхардуулан олгосон байна.	62,360,000.00	Албан томилолтын зардалтай давхардуулан илүү олгосон хоол, үнааны хөнгөлөлт 62.3 сая төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлэх	10/30/2026	Хугацаа болоогүй
19	Зөвлөмж	Олгохоор тооцсон цалинг орлогын дэлгэрэнгүй тайланд 755.6 сая төгрөгөөр илүү, мөнгөн гүйлгээний тайланд 257.5 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийн тайланд 366.8 сая төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан, цалингийн батлагдсан төсвийг 963.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн; - Зарим ажилчдын хавсран ажилласан ажил үүрэг тодорхой бус байхад хавсран ажилласны нэмэгдэл олгосон; - Удирдах албан тушаалтны цалингийн дэлгэрэнгүй бүртгэлээс илүү цагийн тооцоллыг түүвэрлэн шалгахад санхүүгийн тайлан гаргахад холбогдох журмыг зөрчин илүү цагийн хөлсөнд 1.2 сая төгрөгийг олгосон байна.	2,344,479,518.29	Цалинг холбогдох журмын дагуу үнэн зөв тооцоолж олгох, бүртгэлд тусгах, батлагдсан цалингийн санд багтаан зарцуулах.	10/30/2026	Хугацаа болоогүй
20	Зөвлөмж	Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 54,676.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 189 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, 1. Төрийн худалдан авах ажиллагааны газар болон салбаруудад худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар эрх шилжүүлсэн[ED12.1][ЭА12.2] 25,972.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 57 ажлаас 5,135.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 53 ажил хэрэгжээгүй; 2. Нэг эх үүсвэрээс худалдан авахаар төлөвлөсөн 2,658.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ажлаас 801.8 сая мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ажил хэрэгжээгүй; Захиалагчийн хяналтын газраас худалдан авах ажиллагаат зохион байгуулахаар төлөвлөсөн 26,045.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 114 ажлаас 16,820.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 ажил тус тус	0	Худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батлах, хуулиар тогтоосон хугацаанд үр дүнтэй зохион байгуулах.	10/30/2026	Хугацаа болоогүй
21	Төлбөрийн акт	Тайлант онд хөрөнгө оруулалтын ажил гүйцэтгэсэн гүйцэтгэгч 4 байгууллагын норм, нормативын санд төвлөрүүлэх 43.9 сая төгрөгийг холбогдох дансанд шилжүүлээгүй байна.	43,974,688.00	Норм, нормативын санд шилжүүлээгүй хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлэх.	10/30/2026	Хугацаа болоогүй
22	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал оны эцэст салбаруудын орлого, зарлагын төлөвлөгөөг өөрчлөн батална бөгөөд зарим салбарууд төлөвлөгөөний дагуу орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд: - Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба 583.0 сая төгрөг, Нисэхийн журам зохиолт, шалгалтын нислэгийн алба 38.1 сая төгрөг, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба 25.9 сая төгрөг, Нисэхийн спорт сургалтын цогцолбор 3.2 сая төгрөг, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий, Сүхбаатар, Тосонцэнгэл нисэх буудлууд 152.8 сая төгрөгийн орлогыг тус тус дутуу төвлөрүүлсэн; - Нисэхийн аюулгүй байдал хамгаалалтын алба 175.1 сая төгрөг, Баянхонгор нисэх буудал 54.5 сая төгрөгийн зардлыг тус тус хэтрүүлсэн байна.	1,032,674,000.00	Салбар нэгжүүд орлогыг бүрэн төвлөрүүлдэггүй, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулдаггүй зөрчлийг арилгах.	10/30/2026	Хугацаа болоогүй
23	Зөвлөмж	ИНҮТ ТӨХХК-д 2025-2027 онд хэрэгжүүлэх хамтын гэрээг байгуулахдаа 2025 оны санхүүгийн жилийн тайланг бэлтгэж, баталгаажуулаагүй байхад тухайн онд компани ашигтай ажилласан тохиолдолд төсөвт тодотгол хийж, үндсэн цалингийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлэх, 2026 онд 14-20 хувиар, 2027 онд 10 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан нь хөдөлмөрийн дотоод журам, цалин хөлсний журмын цалин хөлсийг шинэчлэн тогтоох холбогдох заалтуудтай уялдуулаагүй байна.	0	Хамтын гэрээг байгуулахдаа холбогдох хууль тогтоомж, компанийн батлагдсан дотоод журмуудын холбогдох заалтуудыг мөрдөх	10/30/2026	Хугацаа болоогүй
24	Зөвлөмж	Нийт 4,349.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий 86 тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй, ээмшигч тодорхойгүй, үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 70 тээврийн хэрэгслийн гэрчилгээ бусад байгууллагын нэр дээр бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл тээврийн хэрэгслийн гэрчилгээнээс зөрүүтэй, автомашины марк, зориулалт, улсын дугаар тодорхойгүй байна.	4,349,818,300.00	Үндсэн хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, тээврийн хэрэгслийн гэрчилгээг шилжүүлэн авах, ээмшигчийг тодорхой болгох.	10/30/2026	Хугацаа болоогүй
25	Зөвлөмж	Компанийн салбар, нэгжүүд санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэдэггүй, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнүүлээгүй нь батлагдсан хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх, төсвийг зохистой удирдаж, төлөвлөсөн ажлыг хугацаандаа гүйцэтгэх, хариуцлагын тогтолцоо алдагдах эрсдэлтэй байна.	0	Салбар нэгжүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхдээ төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлтийг хангасан эсэхэд тавих хяналтыг сайжруулах.	10/30/2026	Хугацаа болоогүй
26	Зөвлөмж	Тайлант онд дотоод аудитын газар нийт 10 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 4 салбар нэгж, 1 харьяа дээд байгууллагын санал, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх аудитын хуваарьт ажлыг хугацаандаа гүйцэтгээгүй байна.	0	Тайлант онд төлөвлөсөн ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгэх.	10/30/2026	Хугацаа болоогүй

27	Албан шаардлага	Тайлант онд компанийн бүтцийг шинэчлэн батлахдаа Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 04/25 дугаар тогтоолоор 1 дэд захирал, 4 ерөнхий менежер, мөн оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 08/25 дугаар тогтоолоор бүтцийг өөрчилж 1 ерөнхий менежерийн орон тоотой байхаар баталсан байна. Гүйцэтгэх удирдлага зохион байгуулалтын бүтэц шинэчлэн баталсантай холбогдуулан ажлын байрны жагсаалт, орон тоог өөрчлөн батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж, дэд захирал, захирал, ерөнхий менежер, менежер, газрын дарга, хэлтсийн дарга, хэсгийн дарга зэрэг өөр нэршилтэй албан тушаалын орон тоог давхардуулан бий болгосон байна. Тухайлбал, Нэг салбарт захирал, дэд захирал, менежер, хэлтсийн дарга, хэсгийн даргын орон тоог батлажээ.	0	Бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны жагсаалт, орон тоог батлахдаа хуулиар хориглосон өөр нэршилтэй албан тушаалын орон тоог давхардуулан бий болгосон зөрчлийг таслан зогсоох	10/30/2026	Хугацаа болоогүй
	Нийт		22,980,220,233.29			

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨХХК-ИЙН ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2026 оны 06 сарын 30

д/д	Аудитад хамрагдах нэгж	Аудит хийх хугацаа	Аудитын хамрах хүрээ		Хэрэгжилт	Аудитын багийн гишүүн
			Хамрах хугацаа	Үйл ажиллагааны чиглэл		
	Төлөвлөгөөт аудит					
1	Булган аймаг дахь "Булган" нисэх буудал	II улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 20-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ний өдрийг хүртэлх хугацаанд тус нисэх буудлын санхүү, худалдан авах ажиллагаа, захиргаа болон хүний нөөцийн үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүүгийн чиглэлээр 7, худалдан авах ажиллагааны чиглэлээр-1, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлээр 3 нийт 11 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-8, Булган нисэх буудалд-16 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	**Н.Баттөр** Г.Наранчимэг Ч.Шүрэнхүү
2	Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал	I улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 03 дугаар сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд тус нисэх буудлын санхүү, худалдан авах ажиллагаа, захиргаа болон хүний нөөцийн үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүүгийн чиглэлээр 18, худалдан авах ажиллагааны чиглэлээр-2, захиргаа хүний нөөцийн үйл	**Ч.Нямсүрэн** Ч.Шүрэнхүү Б.Нанжид

					ажиллагааны чиглэлээр 5 нийт 25 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-10, Нисэх буудлуудын үйлчилгээний газарт-2, Бодлого төлөвлөлтийн газарт-2, Алтай нисэх буудалд-19 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	
3	Баянхонгор аймаг дахь "Баянхонгор" нисэх буудал	II улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2026 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 03 дугаар сарын 07-ны өдрийг хүртэлх хугацаанд тус нисэх буудлын санхүү, худалдан авах ажиллагаа, захиргаа болон хүний нөөцийн үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүүгийн чиглэлээр 13, худалдан авах ажиллагааны чиглэлээр-2, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлээр 9 нийт 24 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-11, Нисэх буудлуудын үйлчилгээний газарт-2, Бодлого төлөвлөлтийн газарт-2, Баянхонгор нисэх буудалд-21 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	**Ч.Нямсүрэн** Г.Наранчимэг Б.Нанжид
4	Хөвсгөл аймаг дахь "Мөрөн" нисэх буудал	II улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 20-ний өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд тус нисэх буудлын санхүү, худалдан авах ажиллагаа, захиргаа болон хүний нөөцийн үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүүгийн чиглэлээр 6, худалдан авах ажиллагааны чиглэлээр-2, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлээр 4 нийт 12 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-7, Мөрөн нисэх буудалд-10 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	**Н.Баттөр** Г.Наранчимэг Ч.Нямсүрэн

5	Увс аймаг дахь "Дэглий цагаан" нисэх буудал	I улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 20-ний өдрөөс 06 дугаар сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд тус нисэх буудлын санхүү, худалдан авах ажиллагаа, захиргаа болон хүний нөөцийн үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүүгийн чиглэлээр 6, худалдан авах ажиллагааны чиглэлээр-2, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлээр 4 нийт 12 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-7, Мөрөн нисэх буудалд-10 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	**Н.Баярмаа** Г.Наранчимэг
6	Ховд аймаг дахь "Ховд" нисэх буудал	III улирал	2025 - 2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ны өдрийг хүртэлх хугацаанд тус нисэх буудлын санхүү, худалдан авах ажиллагаа, захиргаа болон хүний нөөцийн үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүүгийн чиглэлээр 11, худалдан авах ажиллагааны чиглэлээр-2, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлээр 8 нийт 21 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-8, Нисэх буудлуудын үйлчилгээний газарт-1, Ховд нисэх буудалд-21 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	**Н.Баярмаа** Ч.Нямсүрэн Г.Наранчимэг Б.Нанжид
7	Өмнөговь аймаг дахь "Гурвансайхан" нисэх буудал	I улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 20-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд тус нисэх буудлын санхүү, худалдан авах ажиллагаа, захиргаа болон хүний нөөцийн үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүүгийн чиглэлээр 6, худалдан авах ажиллагааны чиглэлээр-1, захиргаа хүний нөөцийн үйл	**Н.Баярмаа** Ч.Шүрэнхүү Б.Нанжид

					ажиллагааны чиглэлээр 3 нийт 10 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-6, Гурван сайхан нисэх буудалд-9 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	
8	Сүхбаатар аймаг дахь "Баруун-Урт" нисэх буудал	II-III улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	Хугацаа болоогүй.	**Н.Баярмаа** Г.Наранчимэг Б.Нанжид
9	Дорнод аймаг дахь "Чойбалсан" нисэх буудал	II-III улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	Хугацаа болоогүй.	**Н.Баярмаа** Г.Наранчимэг Б.Нанжид
10	Өвөрхангай аймаг дахь "Арвайхээр" нисэх буудал	II-III улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	Хугацаа болоогүй.	**Ч.Нямсүрэн** Ч.Шүрэнхүү Б.Нанжид
11	Дундговь аймаг дахь "Мандалговь" нисэх буудал	II-III улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2026 оны 05 дугаар сарын 20-ний өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд тус нисэх буудлын санхүү, худалдан авах ажиллагаа, захиргаа болон хүний нөөцийн үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүүгийн чиглэлээр 6, худалдан авах ажиллагааны чиглэлээр-1, захиргаа хүний нөөцийн үйл ажиллагааны чиглэлээр 4 нийт 11 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-9, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албанд-2, Мандалговь нисэх буудалд-9 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	**Н.Баярмаа** Ч.Шүрэнхүү Б.Нанжид
12	"Буянт-Ухаа" олон улсын нисэх буудал,	III улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа,	Хугацаа болоогүй.	**Н.Баярмаа** Г.Наранчимэг Б.Нанжид

				хүний нөөцийн үйл ажиллагаа;		
13	Жаргалант сэргээн засах амралт,	III улирал	2026 он	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагаа;	Хугацаа болоогүй.	**Ч.Нямсүрэн** Ч.Шүрэнхүү
14	Аэродром гэрэл суултын алба,	III улирал	2026 он	Хөрөнгийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт;	Хугацаа болоогүй.	**Ч.Нямсүрэн** Г.Наранчимэг
15	Нисэхийн холбоо, навигаци, ажиглалтын алба	III улирал	2026 он	Хөрөнгийн зарцуулалт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт;	"ИНҮТ" ТӨХХК-ийн гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн хүрээнд 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 04-ны өдрийг хүртэлх хугацаанд тус Нисэхийн холбоо навигаци, ажиглалтын албаны тоног төхөөрөмжийн сэлбэг, бараа материалын худалдан авалт, бүртгэл, хадгалалт, хамгаалалт, олголт, зарцуулалтад аудитыг хийж гүйцэтгэсэн болно. Аудитын хүрээнд санхүү, худалдан авах ажиллагааны чиглэлээр нийт 8 асуудал илрүүлж Захиргаа санхүү удирдлагын газарт-5, Бодлого төлөвлөлтийн газарт-2, Агаарын навигаци үйлчилгээний газарт-3, Нисэхийн холбоо навигаци, ажиглалтын албанд-6 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. 100%	**Н.Баярмаа** Ч.Шүрэнхүү Ч.Нямсүрэн Г.Наранчимэг

ХЯНАСАН:
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН МЕНЕЖЕР Н.БАТТӨР

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН: ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АУДИТОР Б.НАНЖИД